

АФГАНИСТАН: ХУВЬСГАЛТ ТЭМЦЛИЙН ТАВАН ЖИЛ

М. Хурметхан.

Афганистаны ард түмэн Афганистаны Ардын Ардчилсан Нам (АААН), хувьсгалт төрөө нягтаар хүрээлэн, ирээдүйгээ цогцлон байгуулахын төлөө тэмцлийн их амжилтаар өөрсдийнхөө яруу алдарт дөрөвдүгээр сарын хувьсгалын таван жилийн ойг тэмдэглэв.

1978 оны 4-р сарын 27-ны өдөр афганы ард түмний түүхэнд үндсэн эргэлтийн анхны өдөр болж, АААН-ын удирдсан зэвсэгт бослого ялж, засгийн эрх ард түмний гарт шилжин, Афганистанд феодализм, империализмыг эсэргүүцсэн ардын ардчилсан хувьсгал мандсан юм. Афганистаны дөрөвдүгээр сарын үндэсний ардчилсан хувьсгал нь афганы нийгмийн хууль ёсны хөгжлийн үр дүн, олон зуун жилийн турш афганы ард түмнээс мөлжигч ангийн эсрэг явуулж ирсэн эвлэршгүй тэмцлийн үр дагавар байлаа. Нөгөө талаар Афганистанд ялсан дөрөвдүгээр сарын хувьсгал бол XX зууны гол үйл явдал болсон агуу их Октябрийн хувьсгалаар эх авсан эрин үеийн дэлхийн хувьсгалт үйл явцын бодит үргэлжлэл, түүний нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн.

Уг хувьсгалын ялалтаар Афганистанд ноёрхогч ангийн улс төр, нийгэм-эдийн засгийн дарангуйлалыг устган, хувьсгалт ардын засаг байгуулагдсанаар АААН-ын анхны программд дэвшүүлэн тавьсан засгийн эрхийг авах стратегийн гол зорилт биелэгдэв.

АААН-ын программын анхны зорилт ийнхүү хэрэгжиж хувьсгалт ардын засаг байгуулагдсан нь гадаад, дотоодын харгис хүчний өнгөлзлөгөөс хувьсгалын ололтыг найдвартай хамгаалан, хөдөлмөрийн олны эрх ашгийг илэрхийлсэн эдийн засаг, нийгэм ссёлын өөрчлөлтийг явуулах үндсэн нөхцлийг бүрдүүллээ. Афганистан дахь хувьсгалт өөрчлөлтийн цаашдын хөгжилтөнд 1979 оны 12-р сарын 27-ны хувьсгалт шинэ шат чухал нөлөө үзүүлэв. Дөрөвдүгээр сарын хувьсгалын шинэ шатны гол ололтын нэг нь АААН-ын удирдан чиглүүлэх роль өсөн бэхжиж нийгмийг удирдах гол хүч болов. Намын эгнээний зохион байгуулалт, улс төр-үзэл суртлын эв нэгдэл хүчтэй болж, ард олны дунд нэр хүнд нь батжсан байна. АААН-ын удирдлагаар байгуулагдсан зуун мянган гишүүнтэй залуучуудын байгууллага, 152 мянган гишүүнтэй үйлдвэрчний эвлэл, хориод мянган гишүүнтэй эмэгтэйчүүдийн байгууллага болон сэхээтнүүдийн зэрэг янз бүрийн уран бүтээлийн нэгдлүүд намаас хэрэгжүүлж буй зорилтыг биелүүлэхэд итгэлтэй туслагч болсон юм.

АААН-ын үйл ажиллагааны цаашдын хөгжилд 1982 оны 3-р сард хуралдсан АААН-ын нийт үндэсний бага хурал чухал үүрэг гүйцэтгэв. АААН-ын нийт үндэсний бага хурал нь дөрөвдүгээр сарын хувьсгалын урагшлах хөдөлгөөний цаашдын чиглэлийг оновчтой заасан юм. Уг хурлаас баталсан «АААН-ын үйл ажиллагааны программ» нь АААН-аас баримтлах гадаад, дотоодын чиг шугамыг тодорхойлов. Тус программд зааснаар дөрөвдүгээр сарын хувьсгал ялмагц АААН-аас хэрэгжүүлж эхэлсэн тус оронд газрын том эзэмшлийг устгах, бага газартай

ба газаргүй тариачдад газар хувиарлан олгох, нийгэм улс төрийн амьдралыг гүнзгий ардчилах, үндэстнүүдийн тэгш эрхийг ханган, эмэгтэйчүүдэд эрх чөлөө олгох, үндэсний эдийн засгийг хөгжүүлэн, улсын секторыг улам бэхжүүлэх, хүн амын соёл, аж амьдралын түвшинг дээшлүүлэн, бичиг үсэггүй байдлыг устгах зэрэг зорилтуудыг улам гүнзгийрүүлэн явуулахаар заажээ. Өөрөөр хэлбэл аз жаргалтай ард түмэнтэй, цэцэглэн хөгжсөн шинэ Афганистан улсыг байгуулахад уг программ чиглэгдэж байна.

Дөрөвдүгээр сарын хувьсгалын дараа АААН-ын удирдлагаар тус орны нийгэм-эдийн засгийн амьдралыг шинэчлэн байгуулах олон арга хэмжээг хэрэгжүүлэн биелүүлсэн хийгээд уг явц үргэлжилсээр байна. Тус улсын цаашдын хөгжилд үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх явдал чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд АААН үүнд ч гол анхаарлаа хандуулж байгаагийн үрээр сүүлийн жилүүдэд Афганистаны эдийн засаг амжилттай хөгжиж байна. Жишээлбэл, өнгөрсөн (1982 оны 3-р сарын байдлаар) онд Афганистаны үндэсний орлого урьдах онтой харьцуулахад 3, 4 хувь өсч 95 миллиард хүрсэн байна. Сүүлийн хоёр жилд үндэсний нийт бүтээгдэхүүн таван хувь нэмэгдэн, нийгмийн хэрэглээний төсөв бараг хоёр дахин өсчээ.

Афганистаны улс ардын аж ахуйд газар тариалан, мал аж ахуй чухал суурь эзэлдэг бөгөөд энэ салбар нийгмийн нийт бүтээгдэхүүний 65-аас илүү хувийг үйлдвэрлэж байна. Тэнд хүн амын бараг 90 хувь нь ажилладаг юм. Афганистанд хөдөө аж ахуйг эрхлэхэд тохиромжтой 17 сая орчим га газар байдаг бөгөөд одоогоор тариалах боломжтой 8 сая га газраас жил бүр үр тариа, жимс, цэцэрлэгийг барагцаалахад 4,5 сая га газар тариалдагаас 2,6 сая га нь услагаатай талбай болно.³ Иймээс энэ салбарт нийгэм-эдийн засгийн үндсэн өөрчлөлт хийх, тэнд орчин үеийн шинжлэх ухаан-техникийн ололт амжилтыг өргөнөөр нэвтрүүлэх, хоршооллох хөдөлгөөнийг өрнүүлэх, атар газар эзэмших, усжуулах, том барилга байгууламж байгуулах нь онцгой ач холбогдолтой юм.

Өнгөрсөн таван жилд хөдөө тосгонд гүн гүнзгий хувьсгалт өөрчлөлт явагдан, тариачдын амьдралд эргэлт гаргав. Афганистаны хүн амын олонхи болох хөдөлмөрч тариачдыг хамарсан газрын шинэтгэлийг амжилттай хийж байна. Үүнд 1981 оны зургадугаар сарын 20-нд АААН-ын Төв Хороо, БНААфгУ-ын Сайд нарын Зөвлөлөөс баталсан «Газрын шинэтгэлийн хууль» онцгой чухал үүрэг гүйцэтгэж байна. Уг хуулинд газрын шинэтгэлийн үндсэн зорилт нь хөдөөгийн нийгэм-эдийн засагт оршиж байгаа феодалын харилцааны үлдэгдлийг устган, газар, усыг шударгаар хувиарлан, тариачдад эд материал, санхүүгийн тусламж үзүүлэх, хоршооллын хөдөлгөөнийг өрнүүлэх, хөдөө аж ахуйн барилга байгууламж барьж байгуулах зэрэг болно. Газрын шинэчлэлтийн явцад газаргүй буюу бага газартай тариачин, хөдөө аж ахуйн ажилчин 300 мянга шахам айл өрхөд 700 мянга орчим га газар хувиарлажээ. Газрын шинэтгэлийн хоёр дахь шатанд дахин 1, 2 сая тариачин өрхөд зохих газар хувиарлан олгож, 370 мянга гаруй тариачин өрх айлд урьд газар олгосон тухай хууль ёсны баталгаа олгох ажил явагдаж байна.⁴

БНААфгУ-ын Хувьсгалт Зөвлөлөөс 1981 оны 12-р сарын 9-нд «Усны тухай» хууль гаргасан нь тус орны хөдөөгийн амьдралд чухал үйл явдал боллоо. Энд усыг ашиглах, шударгаар хувиарлах асуудлыг зохи-

¹ Международная жизнь 1982 № 9. с. 132.

² «Үнэн» 1983. 1. 11

³ «Хивад» 1982. 11. 17

⁴ «Правда» 1982. 9. 22

цуулжээ. Афганистаны газар тариалангийн хөгжилтөд усыг газраас дутуугуй өндөр үнэлдэг юм. Судалгаагаар Афганистанд усны нөөц 50 млрд шоо метр бөгөөд түүнээс зөвхөн 20—25 хувийг ашиглаж байна. Усжуулах систем нь Афганистанд газар тариалан хөгжүүлэхэд маш чухал ач холбогдолтой. Иймээс шуудуу болон усжуулах системийн барилга байгууламж барьж байгуулахад улс их анхаарал тавьдаг. Үүнд зөвхөн 1981 оны 3-р сараас 1982 оны 3-р сарын хооронд усжуулах барилга байгууламжинд 665 сая афган зарав. Одоо 28 том усжуулах систем ажиллаж байгаагаас 5-г нь шинээр байгуулжээ. Шинээр баригдаж байгаа усжуулах системүүдийг ашиглаж эхэлснээр их хэмжээний атар газар эзэмших бололцоотой болно.

Афганистанд баригдсан ба баригдаж буй усжуулах системийн байгууламжинд ЗХУ-аас үзүүлсээр ирсэн тусламжийн ач холбогдол онцгой юм. Ганцхан жишээ дурдахад ЗХУ-ын тусламжаар баригдсан Жалалабадын 70 км урт усжуулах суваг баригдсанаар 25 мянган га талбайг усжуулах боломжтой болсон ба эдийн засгийн хувьд үр ашигтай ажиллаж байна.⁶

Газрын шинэтгэлийн явцад хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлэх талаар анхааран үйлдвэрлэл, үйлчилгээ, эд хэрэглэгч, гар урчуудын хэлбэрээр байгуулж байна. Одоогийн байдлаар Афганистанд хөдөө аж ахуйн хоршооллын тоо 1217 хүрч, эгнээндээ 190 мянган тариачдыг нэгтгээд байна.⁷ Тариачдын аж байдлыг сайжруулах талаар чухал арга хэмжээ авч 1980—1981 онд тэдэнд олгох бордоог 24 хувиар, сортын үрийг 15 хувиар, хөдөө аж ахуйн техникийн үнийг 30 илүү хувиар хямдруулжээ. Үүний хамт улсад худалдах манжингийн үнийг 30, түүхий хөвөнгийнхийг 20 хувиар нэмэгдүүлэв. 1978—1981 онд газрын албан татвар төлөх ёстой байсан 3,4 сая тариачныг 722 сая афганы албан татвараас хэлтрүүлжээ.⁸

АААН, хувьсгалт засгийн газрын дэмжлэгийг тариачид байнга авдаг юм. Энэ нь ялангуяа тариачны аж ахуйг үр, бордоо, аж ахуйн техникээр хангах явдлаар илэрлээ олж байна. Хөдөө аж ахуйн хэрэгцээтэй тоног төхөөрөмж бордоо, үр худалдан авахад зориулан хөдөлмөрч тариачдад улсаас ихээхэн зээл олгожээ.

Афганистаны хөдөө аж ахуйд мал аж ахуй чухал суурь эзэлдэг юм. Иймд мал аж ахуйг тогтвортой өсгөх зорилгоор тэжээлийн баазыг өргөтгөж, ялангуяа нүүдэлчдийг суурьшуулах талаар анхаарч байна.

Афганистанд хувьсгалаас өмнө хөдөө аж ахуй бүхэлдээ хоцрогдмол, гар ажиллагаатай байв. Иймд хөдөөд гар хөдөлмөрийг техникээр сольж, орчин үеийн шинжлэх ухаан техникийн ололтыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилт тулгарч байна. Афганистанд мал эмнэлгийн алба хөгжүүлэх, хөдөө аж ахуйн хортон, ургамлын өвчинтэй тэмцэхэд ЗХУ тусалж байна. Энэ өргөн цар хүрээтэй зорилтыг биелүүлэхэд ЗХУ-аас үзүүлж байгаа техник-эдийн засгийн тусламж онцгой чухал ач холбогдолтой юм. 1979 оны IX сард ЗХУ, Афганистаны хооронд байгуулагдсан гэрээний дагуу ЗХУ-ын тусламжаар Афганистан машин тракторын долоон станц байгуулагдан тариачдын хоршоололуудад үйлчилж байна. Хөдөө аж ахуйд ийм үр дүнтэй арга хэмжээ авч явуулснаар тус салбарын бүтээгдэхүүн өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, дөрөвдүгээр сарын хувьсгалын дараах хугацаанд хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 2,6 хувь өсч хүн амын өсөлтөөс түрүүлэв. Тус салбарыг цаашид

⁴ «Хивад» 1982. 11. 18.

⁶ Демократическая республика Афганистан. М., 1981, с. 109.

⁷ «Хакикатс инклабе саур» 1982. 10. 16.

⁸ «Хакикате инклабе саур» 1982 12. 16.

хөгжүүлэхэд дараах зорилтуудыг хэрэгжүүлэх нь чухал гэж үзэж байна. Үүнд: Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлснээр хүн амыг хүнсний зүйлээр аж үйлдвэрийг түүхий эдээр хангах, экспортын хэмжээг нэмэгдүүлэн улсын секторт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эзлэх хувийн жинг дээшлүүлэх, газар тариалан, мал аж ахуй аж үйлдвэрийн хоорондох үр ашигтай харьцааг бий болгосноор газар тариалангийн хөгжлийн хурдац аж үйлдвэрээс илүү байх бөгөөд ингэснээр хүн амын аж байдлын түвшинг дээшлүүлэх болно. Энэ нь тосгон дахь нийгэм-эдийн засгийн гол өөрчлөлт газрын шинэчлэл, хоршооллын хөдөлгөөнийг цаашид өрнүүлэхийг шаардах юм.

Хөдөө аж ахуйн механикжсан ферм байгуулах замаар үйлдвэрлэлийн ажиллагааг механикжуулах, тариачдыг орчин үеийн газар тариалангийн мэдлэгтэй танилцуулах, тариачид, малчдад улсаас зээллэг тусламжийн хувьд онцгой арга хэмжээ боловсруулан, мал эмнэлгийн тусламжийг сайжруулан, билчээрийг сайн дурын үндсэн дээр хувиарлах, хоршооллын журмаар орон сууц, жижиг үйлдвэрлэлийн барилга барих ажээ.

Аж үйлдвэрийн хөгжил хурдсаж хүнс, эрчим хүчний болон бусад төрлийн үйлдвэрийн шинэ гзар, барилга байгууламжууд ашиглалтанд орсон байна. БНААфГУ-ын аж үйлдвэрийн үндсэн салбарууд байгалийн хий, чулуун нүүрс, нефть олдворлох, хэвлэх үйлдвэр, мод боловсруулах мэт нь улсын секторт харьяалагдана. Тус улсын аж үйлдвэрт улсын секторын нийт бүтээгдэхүүний үндсэн хэсгийг афган-зөвлөлтийн хамтын ажиллагааны байгууламжууд үйлдвэрлэн гаргаж байна. Энэ оны (1982 оны 9-р сарын байдлаар) эхний зургаан сард улсын болон холимог салбарын аж үйлдвэр өнгөрсөн оны мөн үеийнхээс 3,7 хувь их бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ. Бөс бараа, ноосон нэхмэлийн үйлдвэрлэл 28 хувь, улаан буудайн гурил 5,1, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 9,2 хувь, цементны үйлдвэрлэл 43,7 хувь, нүүрс олзворлох хэмжээ 8 хувь тус тус нэмэгджээ.⁹ Сүүлийн жилүүдэд улсын секторт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж байгаа нь үндэсний аж үйлдвэрийн өсөлтөд чухал түлхэц өгч байна. Аж үйлдвэрийн өсөлт хурдсахын хамтаар үндэсний ажилчин ангийн тоо өсөн нэмэгдэж, тэдний аж байдлыг сайжруулах талаар нам байнга анхаарч байдгийн үр дүнд цалин хөлс нь нэмэгдэн, нийгмийн даатгалын систем бүрэлдэн тогтжээ.

Афганистаны аж үйлдвэрийг цаашид эрчимтэй хөгжүүлэхэд хувьсгалт засгийн газар гол анхаарлаа хандуулж байна. Уг салбрыг эрчимтэй хөгжүүлснээр 10 жилийн дараа гэхэд аж, үйлдвэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах төдийгүй экспортын ихээхэн нөөцтэй болохоор тооцоолж байна.

ААН, БНААфГУ-ын засгийн газраас нийгэм-эдийн засгийн бүхий л салбарт хэрэгжүүлсэн өргөн далайцтай арга хэмжээний дотор ардын боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хийсэн хувьсгалт өөрчлөлт үлэмж үр дүнд хүрч байна. ААН-аас дэвшүүлсэн бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших иж бүрэн программын ачаар сургуульд хамрах хүүхдийн тоо эрс нэмэгдэж сургуулийн насны бүх хүүхдийн 80 хувь анхан (шатны боловсрол эзэмшиж байна. БНААфГУ-ын засгийн газар ардын боловсролын системд зориулан их хэмжээний зардал гаргаж байна. Тухайлбал жилд долоон мянга гаруй багш бэлтгэж дөрөвдүгээр сарын хувьсгалын шинэ шатны дараа 334 сургуулийг шинээр нээж, 110 сургуулийг засварлаж, оройн 14 сургууль, 17 цэцэрлэг байгуулав.¹⁰ Афганистанд бичиг үсэг үл мэдэх явдлыг устгахад их анхаарч

⁹ «Хакикате ииклабе саур» 1982. 12. 7.

¹⁰ «Хакикате инклабе саур» 1982. 11. 27.

байна. Насанд хүрэгчдийг бичиг үсэгт сургах ажлыг сайн дурын үндсэн дээр явуулан сүүлийн гурван жилд хоёр сая орчим хүнийг бичиг үсэгт сургах курст хамруулсан байна.¹¹

Тус оронд дээд болсвосрол, тусгай мэргэжлийн систем цаашид хөгжиж, үндэсний шинжлэх ухааны академи байгуулагдан, аж үйлдвэр, хөдөө аж ахуйг шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлэх программ боловсруулж байна. Энд ард түмэнд эмнэлгийн тусламж үзүүлэх явдал өргөжиж, эрүүлийг хамгаалах систем улам боловсронгуй болж, тус улсын түүхэнд анх удаа үнэ төлбөргүй эмчлэх системийг эхлэн нэвтрүүлжээ.

Дээрхи салбаруудаар ойрын жилүүдэд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд: насанд хүрэгчдийн дунд бичиг үсэг үл мэдэх явдлыг арилган, сургуулийн насны хүүхдийг 100 хувь сургуульд хамруулж, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын тоог олшруулна. Ихэнх мужид хөдөө аж ахуйн техник мэргэжлийн сургууль байгуулахаар төлөвлөж байна. Дээд боловсролын системийг цаашид хөгжүүлж, Балх, Кандагар мужид их сургууль шинээр нээгдэнэ.

Афганистанд нийгэм-эдийн засгийн эдгээр хувьсгалт арга хэмжээнүүдийг цаашид гүнзгийрүүлэхэд түүний гадаад хүчин зүйл онцгой үүрэгтэй нь тодорхой. Ялангуяа ЗХУ социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой тогтоосон улс төр, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухааны салбар дахь хамтын ажиллагаа нь Афганистаныг социалист чиг баримжаагаар хөгжих бодит нөхцлийг бүрэлдүүлж байна.

Дөрөвдүгээр сарын хувьсгал нь ингэж социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой Афганистаны найрамдал, хамтын ажиллагааг чанарын шинэ шатанд гаргалаа.

Дөрөвдүгээр сарын хувьсгалын үр дүнд байгуулагдсан БНААфГУ-ыг БНМАУ албан ёсоор хүлээн зөвшөөрсөн цагаас хойш тус хоёр орны уламжлалт найрамдалт харилцаа шинэ үзэл санаа, агуулга хэлбэрээр өрөгжин хөгжих боломж нээгдсэн билээ. Өнгөрсөн хугацаанд манай нам, засгийн газар АААН, БНААфГУ-ын засгийн газраас улс орныхоо дотоодод хэрэгжүүлж буй нийгэм-эдийн засгийн хувьсгалт өөрчлөлт болон БНААфГУ-ын энх тайванч санаачлагуудыг бүрэн дүүрэн дэмжсээр ирсэн юм.

Тус хоёр орны хоорондын харилцааны мөн чанар, агуулгыг илэрхийлэн МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю. Цэдэнбал МАХН-ын XVIII их хуралд тавьсан МАХН-ын Төв Хорооны тайлан илтгэлдээ «Афганы ард түмэн ялж, Бүгд Найрамдах ардчилсан Афганистан Улс байгуулагдсаны дүнд манай хоёр орон, ард түмний харилцаа шинэ шатанд гарлаа. Энэ харилцаа пролетарийн интернационал замын зарчмын үндсэн дээр, найрамдал, бүрэн харилцан ойлголцох үзэл санааны дагуу амжилттай хөгжиж байна»¹² гэж тэмдэглэсэн билээ.

Афганистаны дөрөвдүгээр сарын хувьсгалын ялалт, Афганистанд явагдаж буй хувьсгалт өөрчлөлтийг гэдрэг ухраахын тулд империализмын зүгээс Афганистаны эсрэг явуулж буй дайсагнасан үйл ажиллагааг БНМАУ-ын засгийн газар, монголын ард түмэн эрс буруушаан эсэргүүцэж, ах дүү афганистаны ард түмэнтэй эв санааны бат нэгдэлтэй байгаагаа илэрхийлсээр байна. Афганистаны хувьсгал, ард түмнийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн эв санаа найрамдлын долоо хоногийг 1979 оны 4-р сарын 21—27-нд манай орон даяар зохион явуулсан юм.

¹¹ «Хакикате инклабе саур» 1962. 11. 27. (1980 онд 55 мянга, 1981 онд 550 мянга, 1982 онд 632500 хүнийг даэрх курсуудад суралцуулсан байна).

¹² МАХН-ын XVIII их хурал. УБ., 1981. 29-р тал.

БНМАУ, БНААфгУ-ын хоорондын хамтын ажиллагаа өнгөрсөн таван жилд олон салбарт амжилттай хөгжиж ирлээ. Монгол, Афганистаны хооронд нам, төрийн шугамаар төлөөлөгчид харилцан айлчлах, шинжлэх ухаан, соёл, урлаг, спортын салбарт эрдэмтэд, жүжигчид, тамирчид солилцох, үзэсгэлэн, кино үзлэг харилцан зохион байгуулах зэрэг ажил зохиож байгаа нь хоёр ард түмэн харилцан ойлголцох, нэг нэгийнхээ туршлагаас суралцахад сайхан боломж олгож байгаа юм.

Монгол, Афганистаны хөгжлийн түүх, аж төрөх ёсонд адил төстэй зүйл цөөнгүй байдаг билээ. Иймээс манай орны капиталист бус хөгжлийн замын түүхэн туршлагыг афганистаны хөдөлмөрчид ихээхэн сонирхож байгаа нь зүй ёсны хэрэг юм. Түүнтэй холбогдуулан ААН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНААфгУ-ын хувьсгалт зөвлөлийн дарга Бабрак Кармаль хэлэхдээ: «Улс үндэстний асуудал, соёлын хувьсгалын асуудлыг шийдвэрлэхдээ хөгжлийн капиталист шатыг алгасан феодализмаас социализмд шилжин орсон Монголын туршлагад бид тулгуурлаж байна»¹³ гэжээ. Монголын ард түмэн өөрийн түүхэн туршлагаа афган ах дүү нартайгаа хуваалцахад хэзээ ч бэлэн байдаг бөгөөд афганистаны ард түмний шинэ нийгэм байгуулах тэмцэлд нь туслахыг өөрийн интернационалч үүргээ гэж үздэг юм.

Афганистаны ард түмэн дөрвөн жилийн турш империалистуудын өдөөсөн зарлаагүй дайны нөхцөлд эх орондоо хувьсгалт өөрчлөлтийг хэрэгжүүлж байна. АНУ тэргүүтэй империалист бүлгийнхэн БНААфгУ-ын дотоод хэрэгт хөндлөнгөөс бүдүүлгээр оролцоор байгаа нь тус орныг түгшүүртэй байлгах гол шалтгаан болж байна. Афганистаны эсрэг явуулж буй зарлаагүй дайны шууд хариуцлагыг империалист гүрнүүд, юуны өмнө афганы хувьсгалын эсэргүү нарт одоо хүртэл зүйл бүрээр тусалсаар байгаа АНУ, түүнчлэн Афганистаны эсрэг түрэмгийлэлд хамсан оролцогч бусад орон хүлээх ёстой. АНУ, Пакистан болон тэдний холбоотнууд Афганистаны эсрэг зэвсэгт түрэмгийлэл шууд үйлдэх замд орсон 1979 оны эгзэгтэй үед БНААфгУ-ын засгийн газрын удаа дараагийн хүсэлтийг хүлээн авч ЗХУ өөрийн интернационалист үүргээ биелүүлэн, Афганистанд гаднаас халдан довтлох аюулыг зогсоох зорилгоор Зөвлөлт-Афганистаны хамтын ажиллагааны гэрээний дагуу, түүнчлэн өмнөд хилийнхээ аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс хязгаарлагдмал тооны цэргээ Афганистанд түр оруулсан бөгөөд гаднын түрэмгийлэл зогсмогц тэндээс цэргээ гаргана гэдгээ аль эрт мэдэгдсэн юм.

Империалистууд тус орны дотоод хэрэгт хөндлөнгөөс зэвсгийн хүчээр оролцож, хорлон сүйтгэх ажил явууллагаа тасралтгүй үргэлжлүүлж байгаа хэдий боловч Афганистан улс өөрийн сонгож авсан замаар тууштай замнаж байна. Шинэ Афганистаныг бүтээн байгуулах тэмцэлдээ афганы ард түмэн ЗХУ ах дүү социалист бусад орон, бүх дэвшилт хүчний өргөн дэмжлэгийг хүлээж байна. Афганистаны ард түмэнтэй хувьсгалт эв санааны нэгдэлтэй байдаг монголын ард түмэн, шинэ амьдрал цогцлоон байгуулах, хувьсгалт ололтоо хамгаалах, нийгэм-эдийн засагт хийж буй хувьсгалт өөрчлөлтөндөө олж буй афганы ард түмний амжилтанд ямагт бахдан баярлаж байдаг юм.

¹³ «Үнэн 1981. III. 25

5 ЛЕТ АФГАНСКОЙ РЕВОЛЮЦИИ.

(Р е з ю м е)

В апреле 1978 года под руководством Народно-демократической партии в Афганистане победила антифеодальная, антиимпериалистическая народная революция. Победа революции была результатом закономерного развития афганского общества и многовековой непримиримой борьбы народа с эксплуататорами. В тоже время апрельская резолюция явилась практическим продолжением и составной частью всемирного революционного процесса, начало которому положила Великая Октябрьская социалистическая революция.

С псбедой апрельской революции в Афганистане сложились благоприятные условия для проведения широкой программы социально-экономических и политических реформ, ликвидации политического и экономического господства феодалов.

Новый этап афганской революции, начавшийся в декабре 1979 г. гарантировал успешное проведение коренных революционно-демократических реформ в стране. На этом этапе революции значительно укрепилась руководящая роль Народно-демократической партии Афганистана. Большую роль в дальнейшем усилении влияния НДПА сыграла первая общенациональная конференция НДПА, (состоявшаяся в Кабуле в марте 1982 года. Конференция определила направления поступательного развития апрельской революции, приняла «Программу действий НДПА».

В «Программе» определены конкретные цели и задачи по преодолению социально-экономических трудностей на новом этапе национально-демократической революции: проведение земельной реформы, обеспечение социального равноправия национальностей, развитие национальной экономики, повышение жизненного и культурного уровня народа.

Важную роль в защите и углублении афганской революции играет внешний фактор. Сотрудничество ДРА с Советским Союзом, другими странами социалистического содружества, расширение взаимных политических, торгово-экономических, культурных и научно-технических связей создают реальные условия для успешного развития страны.

Несмотря на постоянные провокации и подрывную деятельность реакционных группировок, руководимых извне международным империализмом во главе с США, Афганская республика уверенно идет по избранному ею пути, и в этом она опирается на солидарность и поддержку Советского Союза, братских стран социализма, всего прогрессивного человечества.

Между МНР и ДРА установились прочные отношения, основанные на принципах пролетарского интернационализма.

Отношения между двумя странами, ныне охватывающие разные стороны общественной жизни, с каждым годом все более крепнут и развиваются, обогащаются новым содержанием и строятся на основе полного взаимопонимания и доверия.